



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/232

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шуурхай удирдлагын нэгдсэн төвийг байгуулах, гудамж талбайн камержуулалтыг өргөтгөх ажлын төслийг боловсруулах ажлын хэсэг Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, судалгаа хийхэд дэмжлэг үзүүлж, шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 957420 /Есөн зуун тавин долоон мянга дөрвөн зуун хорин/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ